

“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” II шат “Төслийн мэдээ” сонин

Сэдэв

- “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийн хурлын талаар та мэдэх үү?
- Бүх аймаг, дүүрэг кейс хэлэлцүүлэг зохион байгуулж байна.
- Зорилтот цэцэрлэгүүд дэх “Тэгш хамран сургах боловсролын загвар”-ыг нэвтрүүлэх үйл ажиллагааны үр дүнгийн танилцуулга
- Сургуулийн дэмжлэгийн багийн жилийн үйл ажиллагааны танилцуулга
- Тэгш хамран сургах боловсролын тухай багш нарт зориулсан видео хичээлийг толилуулж байна.

2023 оны
9 дүгээр сар
Дугаар 4



“Төслийн мэдээ” сонины дугаар 4-тэй танилцсан танд баярлалаа. Энэ удаагийн дугаарт салбар комиссын гишүүд, цэцэрлэг, сургуулиудын багш нарын өдөр тутмын үйл ажиллагаанд санаа өгөх мэдээллүүд болон өнөөг хүртэлх төслийн үйл ажиллагааны үр дүнгээс нийтэллээ.

Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын талаар та мэдэх үү?

Энэ жил танай аймаг, дүүргийн “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл” хурал зохион байгуулсан уу?

“Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал” гэдэг нь тухайн жилийн 9-р сараас боловсролын үйлчилгээнд хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй болон ямар нэг дэмжлэг шаардлагатай хүүхдүүд, эсхүл 6 нас хэтэрсэн ч хөгжлийн бэрхшээлийнхээ улмаас боловсролд хамрагдаагүй хүүхдүүдийг сургуульд элсүүлэх төлөвлөгөө боловсруулах, холбогдох байгууллага, хүмүүсийн чиг үүргийг тодорхойлох, үзүүлж буй дэмжлэгийнхээ хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зорилго бүхий уулзалт юм. Энэ талаар ХНХЯ-ны сайд, ЭМ-ийн сайд, БШУ-ны сайдын 2021.12.30-ны өдрийн хамтарсан тушаал дахь “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал”-д дараах байдлаар заажээ.

Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүн

- Тухайн шатны Засаг даргын ажлын албаны төлөөлөл, эсхүл ЗДТГ-ын төлөөлөл (Зөвлөлийн дарга);
- Тэгш хамран сургалт хариуцсан мэргэжилтэн (Нарийн бичгийн дарга);
- Салбар комиссын боловсрол хариуцсан мэргэжилтэн;
- Салбар комиссын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн;
- Цэцэрлэг, ЕБС-ийн удирдлагын төлөөлөл;
- Эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл.

Хэрэгжүүлэх чиг үүрэг

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьдрал, ахуйн нөхцөл, суралцах онцлог хэрэгцээг судлан хэлэлцэж, холбогдох маягтад тэмдэглэх.
- Хүүхдэд шаардагдах эрүүл мэнд, нийгмийн халамж, сэргээн засалтын гэх мэт нэмэлт дэмжлэг, боловсролд хамрагдахад шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнийг тодорхойлж холбогдох үйлчилгээнд хамруулах зохицуулалтыг хийх;
- Эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлт, эрүүл мэндийн байдал, хөгжлийн онцлогийг харгалзан боловсролд хамрагдах сургалтын байгууллага, суралцах арга хэлбэрийг сонгох.



Хөвсгөл аймгийн БХДЗ-ийн хурал
(2023.05.31)

“Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал” зохион байгуулахдаа, салбар комисс нь дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийн нэрсийн жагсаалт гаргах, нарийн бичгийн дарга нь тухайн өдрийн хуваарийг гаргах, холбогдох хүмүүстэй харилцан зохицуулалт хийх, “Сургуульд орохын өмнөх шилжүүлэх хуудас”, “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэр” зэрэг шаардлагатай бичиг баримтыг бэлтгэдэг. Хуралд хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч болон цэцэрлэгийн багш нар хүүхдийн нөхцөл байдлыг тайлбарлах бөгөөд сургуульд ороход ямар бэрхшээл тулгардаг, түүнийг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцана.

Бүх хүүхдэд боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжийг олгох үүднээс улс орон даяараа “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал” зохион байгуулж хэвшихийг та бүхэнд уриалж байна.

Бүх аймаг, дүүрэг кейс хэлэлцүүлэг зохион байгуулж байна.

Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэгт ажиллаж буй салбар комисс нь тус төсөл хэрэгжиж эхэлснээс хойш хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчдыг дэмжих зорилгоор нэг буюу хэд хэдэн удаа кейс хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Кейс хэлэлцүүлгээр дамжуулан хүүхдүүд сургуульд үргэлжлүүлэн суралцахад бэрхшээлтэй байдаг нөхцөл байдал, тэдний асран хамгаалагчдад үзүүлэх дэмжлэг, үйл ажиллагаагаа судлан хэлэлцдэг. Салбар комиссын гишүүд болон холбогдох байгууллагууд хуралдаж, хүүхдийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө боловсруулах ба дэмжлэгийн үйл ажиллагаанд оролцох байгууллага, хүмүүсийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгодог. Ингэснээр, хүүхдийн хөгжлийг эерэгээр чиглүүлэх боломж бүрддэг. Төсөл эхэлснээс хойших хагас жил орчмын хугацаанд буюу 2021.05 сар хүртэл 14 аймаг, дүүрэг кейс хэлэлцүүлэг зохион байгуулсан бол, 2 жилийн дараах 2023.05 сарын байдлаар бүх аймаг, дүүрэг кейс хэлэлцүүлэг зохион байгуулжээ.


Кейс хэлэлцүүлгээр дамжуулан хүнд кейсийг авч хэлэлцэн шийдвэр гаргах бөгөөд хэдийгээр салбар комиссын гишүүдийн ажлын ачаалал нь нэмэгдэх магадлалтай ч хүүхдүүд болон тэдний эцэг эхийн санал хүсэлтийг хүндэтгэн үзэх байдлаар цэцэрлэг, сургууль, боловсрол, эрүүл мэнд, халамжийн мэргэжилтнүүд хамтран ажилласнаар шийдэлд хүрэхэд хялбар болно. Цаашилбал, дараа дараагийн хүнд кейсийг шийдвэрлэхэд тустай санаа оноог ч өгдөг байна.



Зорилтот цэцэрлэгүүд дэх “Тэгш хамран сургах боловсролын загвар”-ыг нэвтрүүлэх үйл ажиллагааны үр дүнгийн танилцуулга

Тус төсөл нь цэцэрлэгүүдэд тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох, багш нарыг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэн тэгш хамран сургах боловсролын загварыг цэцэрлэгт нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн. Энд, нийслэл болон Дорнод, Төв, Өмнөговь, Хөвсгөл, Ховд аймгийн нийт зорилтот 36 цэцэрлэгийн үйл ажиллагааны үр дүнгээс танилцуулъя.

Зорилтот цэцэрлэгүүдийн сайн жишээ



Дотоод орчин бүрдүүлэх (1)
Тэргэнцэртэй хүүхдийн налуу зам (Ховд аймаг, Зэрэг сум)



Дотоод орчин бүрдүүлэх (2)
Аутизмтай хүүхдийн булан (Төв аймаг, “Унагалдайн андууд” цэцэрлэг)



ГСТ боловсруулах, дэмжлэгийн багаар хэлэлцэх
(Бүх оролцогч цэцэрлэгт хэрэгжиж байна)



Багш нарыг чадавхжуулах, арга зүй сайжруулах сургалт
(Бүх оролцогч цэцэрлэгт хэрэгжиж байна)



Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулалт
Даавуун шүхэр (Төв аймаг, “Унагалдайн андууд” цэцэрлэг)



Тэгш хамруулсан бүлэг
Сургалтын аливаа үйл ажиллагаанд дахь багшийн туслахын оролцоо (Бүх оролцогч цэцэрлэгт хэрэгжиж байна)

2022 оны 11 сарын сүүлчээр 33 нь хариу өгснийг олох үндсэн дээр төсвийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Тусуулт	Үйл ажиллагааны нэр	Далтгаруулж	Хариуцагч гэгч	2022 он			
					Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Төлөвлөгөө
		Тэгш хамран сургах боловсролын зохион байгуулалтын бие болгох						
1	Дотоод орчин бүрдүүлэх	1. Дотоод орчин бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Тэгш хамран сургах боловсролын загварыг нэвтрүүлэх, өргөтгөх үйл ажиллагаа	Зоригт С.Балцруу				
2	Багш нарыг чадавхжуулах, арга зүй сайжруулах сургалт	2. Багш нарыг чадавхжуулах, арга зүй сайжруулах сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах	Багш нарыг чадавхжуулах, арга зүй сайжруулах сургалтын үйл ажиллагаа	Дорноговь аймаг, Зэрэг сум				
3	Бусад байгууллагуудтай уяамд хамтрах	3. Бусад байгууллагуудтай уяамд хамтрах үйл ажиллагааг зохион байгуулах	Уламжлалт, сонгодог урлалын үйл ажиллагааг зохион байгуулах	Зоригт С.Балцруу				
4	Бусад байгууллагуудтай уяамд хамтрах	4. Бусад байгууллагуудтай уяамд хамтрах үйл ажиллагааг зохион байгуулах	Тусгай хөрсдөт боловсрол үзвэрүүдийн төлөвлөгөө	Дорноговь аймаг, Зэрэг сум				
5	Бусад байгууллагуудтай уяамд хамтрах	5. Бусад байгууллагуудтай уяамд хамтрах үйл ажиллагааг зохион байгуулах	Тусгай хөрсдөт боловсрол үзвэрүүдийн төлөвлөгөө	Дорноговь аймаг, Зэрэг сум				

Цэцэрлэг нийтээр хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх (1)
ТХСБ-ын төлөвлөгөө (Бүх оролцогч цэцэрлэгт хэрэгжиж байна)



Цэцэрлэг нийтээр хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх (2)
СӨБ хариуцсан мэргэжилтний мониторинг (Бүх оролцогч цэцэрлэгт хэрэгжиж байна)

Сургуулийн өмнө боловсролын багш нарт зориулсан тэгш хамран сургах боловсролын шалгах хуудас төсөл

Зорилго: Энэхүү шалгах хуудсанд багш нарын цаашдын болон хамтрагч бүлэг тэдгээр хамран сургах боловсролын хэрэгжлийг зохион байгуулах үйл ажиллагааны зарчлыг тэгш хамран сургах боловсролын байгуулалттай уяамд хамтрах болон ашигласны талаар судалж үнэлэх.

Цэцэрлэг болон бүлгийн нэр: _____

Огноо: _____ Өдөр: _____

Бэлтгэ	Асуулт			Бэлтгэгч		
	Тийш	Тойр	Аж н ч Бэлтгэ	Тийш	Тойр	Саман, ололтын
1	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Цэцэрлэг нийтээр хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх (3)
ТХСБ-ын шалгах хуудас (Бүх оролцогч цэцэрлэгт хэрэгжиж байна)

“Нээлттэй сургалт, үйл ажиллагаа”-гаар дамжуулан ТХСБ-ыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх

Нийслэл болон дээр дурьдсан 5 аймгийн СӨБ хариуцсан мэргэжилтэн, зорилтот цэцэрлэгийн удирдлагууд аймаг, дүүргийнхээ бусад цэцэрлэг болон бусад аймгийн цэцэрлэгт “Тэгш хамран сургах боловсролын загвар”-ыг түгээн дэлгэрүүлэх, мэдээлэл өгөх үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн. Түүний нэг нь “Нээлттэй сургалт, үйл ажиллагаа” юм. Зорилтот цэцэрлэгүүд сургалтын үйл ажиллагаанаа туршлагыг ойр зэргэлдээх цэцэрлэгийн багш нарт нээлттэй танилцуулан ГСТ-ний хэрэгжилт, хүүхдүүдийн сургалт, үйл ажиллагаанд оролцож буй байдал, сургалтын хэрэглэгдэхүүн зэргийн талаар мэдлэг, ойлголт өгнө. Шашид олонх цэцэрлэгт тулгардаг “Бага сургуультай хамтарч ажиллаж, залгамж холбоо үүсгэх нь” сэдвээр нээлттэй сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн.



Нээлттэй сургалт, үйл ажиллагаа
(Сүхбаатар дүүрэг, 69-р цэцэрлэг)



Сургалтын хэрэглэгдэхүүн болон ашиглах зааврын танилцуулга
(Сүхбаатар дүүрэг, 69-р цэцэрлэг)




Танай сургууль дэмжлэгийн багаа байгуулсан уу? БСШУС-ын 2019.05.14-ний өдрийн А/292-р тушаалын 3.5-д сургуулийн захирлын тушаалаар дэмжлэгийн баг байгуулна гэж заасан байдаг. Бид тус сонины Дугаар 1-д дэмжлэгийн багийн тухай танилцуулж байсан. Энэхүү дугаарт төслийн зорилтот сургууль дахь дэмжлэгийн багийн нэг жилийн үйл ажиллагааны тухай танилцуулж байна.

Дугаар 1-ийг эндээс үзнэ үү.



9-р сар	◆ Сургуулийн захирлын тушаалаар дэмжлэгийн баг байгуулах	
10-р сар	◆ Эхний хурлаа зохион байгуулах. ГСТ боловсруулах, дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийг тодорхойлох. Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах. ◆ Дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийн судалгаа гаргах. ◆ ГСТ боловсруулж батлуулах. ◆ Нийслэлийн сургагч багшаас цахимаар сургалт авах.	
11-р сар	◆ Дэмжлэг шаардлагатай хүүхдийн асран хамгаалагчтай ярилцах. ◆ Хэд хэдэн багш хамтран даун болон аутизмтай хүүхдэд зориулсан хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх. ◆ Бүх асран хамгаалагчдын ойлголтыг гүнзгийрүүлэх брошур бэлтгэх.	
12-р сар	◆ 2 дахь хурлаа зохион байгуулах. ГСТ боловсруулсан анги удирдсан багш нар явцыг тайлагнах. ◆ БШУГ/БХ-ийн мэргэжилтэн багш нарт сургалт зохион байгуулах. ◆ Ариун цэврийн өрөөг тохижуулах, анги танхимын хаягийг жигдлэх.	

1 сар: Сурагчдын өвлийн амралт

2-р сар	◆ ХБХ-ийг дугуйлан, секцэд хамруулах. ◆ Сурагчдын зөвлөлтэй хамтарч “Дохионы хэлний аян” өрнүүлэх.	
3-р сар	◆ 3 дахь хурлаа зохион байгуулах. Анги удирдсан багш дангаар шийдэхэд хүндрэлтэй кейсд авах арга хэмжээний талаар судлан хэлэлцэх. ◆ Сурагчдын зөвлөлтэй хамтарч “Дохионы хэлний аян” өрнүүлэх.	
4-р сар	◆ ГСТ-өөр хичээллэж буй хүүхдийн явцыг бүх багш нарт танилцуулах уулзалт зохион байгуулах.	
5-р сар	◆ 4 дэх хурлаа зохион байгуулах. Нэг жилийн үйл ажиллагаагаа эргэн дүгнэх. ГСТ-нд хийсэн үнэлгээний үр дүнг багш нарт танилцуулах. ◆ Ирэх хичээлийн жилд элсэх хүүхдүүдийн мэдээллийг цэцэрлэг, БШУГ/БХ-ээс хүлээн авах.	
Зуны амралт	◆ Ирэх жил элсэх хүүхдүүдийн дундаас дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийн мэдээллийг цуглуулах. ◆ Сургуулийн орчныг сайжруулах (Анги танхимыг босгогүй болгох, ширээ, сандалын аюулгүй байдлыг шалгах г.м)	

Дээрх жишээгээр та бүхэн ч дэмжлэгийн багаараа идэвхтэй ажиллахыг хүсье.

9 дүгээр сар гарч шинэ хичээлийн жил эхэллээ. Танай сургууль захирлын тушаалаар дэмжлэгийн багаа байгуулсан байх. Тийм бол та бүхэн дэмжлэгийн багаараа сайтар ярилцан энэ хичээлийн жилд хэрэгжүүлэх тэгш хамран сургах боловсролын төлөвлөгөөгөө боловсруулахыг хүсье. Ингэхдээ тэгш хамран сургах боловсролын шалгах хуудас ашиглаарай. Энэхүү шалгах хуудсын дагуу сургуулийнхаа үйл ажиллагааг нягтлан илүү эрчимтэй ажиллах шаардлагатай асуудлууд болон энэ хичээлийн жилд онцгойлон анхаарах үйл ажиллагааг төлөвлөгөөндөө тусгах юм.

Тус төслийн баг, сайн туршлагын эмхэтгэл боловсруулан үндэсний хэмжээний бүх сургуульд түгээхээр төлөвлөсөн. Та уг эмхэтгэлд өөрийн сургуулийн сайн жишээнээс оруулахыг хүсвэл, сүүлийн хуудас дахь төслийн багийн мэйл хаягаар бидэнтэй холбогдож болно.

Шалгах хуудсыг эндээс үзнэ үү.



Тэгш хамран сургах боловсролын тухай багш нарт зориулсан видео хичээлийг толилуулж байна.

Тус төсөл, тэгш хамран сургах боловсролыг түгээн дэлгэрүүлэх үүднээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төдийгүй, бүх хүүхдийг ердийн ангид суралцуулах боломжтой багшлах арга зүйг танилцуулах, хүүхдүүд аюулгүй бөгөөд сонирхолтой байдлаар хичээл сургалтын үйл ажиллагаанд оролцох боломжтой орчин бүрдүүлэхээр ажиллаж байна. Тиймээс бид багш, ажилтнуудын тэгш хамран сургах боловсролын талаарх мэдлэгийг гүнзгийрүүлэхийг чухалчилдаг. Төслийн баг цэцэрлэг, бага, дунд сургуулийн багш нарт зориулсан хөгжлийн дэмжлэг, боловсролын үйлчилгээний чиглэлээрх багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад дэмжлэг үзүүлж байна. Энэ ажлын хүрээнд, Боловсролын ерөнхий газар, ердийн болон тусгай сургуулиуд, их дээд сургуулийн багш нартай хамтран багш нарт зориулсан 35 видео хичээлийг бэлтгэж дууссан. Уг видео хичээлүүдийг Medle.com-д байршуулж эхэлсэн бөгөөд цаашид ч нэмж байршуулна. Видео хичээлүүдийн агуулгыг энд танилцуулъя.

Багш нарт зориулсан 5 төрлийн видео хичээл

Тэгш хамран сургах боловсролын тухай хичээлүүдийг 5 ангилсан бөгөөд ухаалаг утсаар үзэх боломжтой байдлаар үсгийн хэмжээг томсгон дохионы хэлний орчуулгатай бэлтгэсэн. Хичээл бүр 15 минутаас ихгүй бөгөөд богино хугацаанд маш их зүйлийг сурч мэдэх боломжтой.

Ангилал	Агуулга
Тэгш хамран сургах боловсролын үндсийг ойлгох нь	“Монголд хэрэгжүүлэхээр зорьж буй тэгш хамран сургах боловсрол”, “Тэгш хамран сургах боловсролын хууль эрх зүйн орчин”, “Тохирох хэрэглэгдэхүүний агуулга, бодит жишээ”, “Тэгш хамран сургах боловсролын олон улсын чиг хандлага, Монголд хэрэгжсэн төслүүдийн жишээ”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах үйл явц” (Нийт 5 видео)
Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх нь	“Дэмжлэгийн багийн чиг үүрэг ба хэрэгжүүлэх үйл ажиллагаа” (1 видео), (“Бүх хүүхэд хүртээмжтэй сургуулийн орчин бүрдүүлэх нь” 11-р сард танилцуулна.)
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш нарт зориулсан анхан шатны сургалт	“Сургуулийн орчинд үр дүнтэй тэгш хамран сургах боловсролын жишээ, туршлага”, “Хүүхдийн ойлголт ба багшлах арга зүйн анхаарах зүйлүүд” гэсэн 2 видеог 11-р сард танилцуулна.)
Тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх нь (Цэцэрлэг, сургуулийн сургалт)	“Тэгш хамруулдаг ангийн менежмент”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний агуулга, боловсруулах аргачлал”, “Оюуны бэрхшээлтэй хүүхдийн тоо бодох, унших, бичих чадварын үндсэн ойлголтыг заах сургалтын хэрэглэгдэхүүн” (Нийт 10 видео) (“ЕБС-д зохион байгуулах тэгш хамран сургах боловсролын жишиг хичээлийн (Бага ангийн математик, Монгол хэл, хүн ба байгаль, биеийн тамир)” 4 видеог 11-р сард танилцуулна.)
Хөгжлийн бэрхшээлийн ангиллын талаарх мэдлэг	“Хөгжлийн бэрхшээлийн онцлог ба багшлах арга зүй (Оюуны бэрхшээл, тулгуур эрхтний бэрхшээл, харааны бэрхшээл, сонсголын бэрхшээл, аутизм, хэл ярианы бэрхшээл, хэт хөдөлгөөнтөх, анхаарал дутмагших эмгэг, суралцахуйн бэрхшээл)” (Нийт 19 видео)



Оюуны бэрхшээлтэй хүүхдийн тоо бодох чадварын үндсэн ойлголтыг заах сургалтын хэрэглэгдэхүүн



Дэмжлэгийн багийн чиг үүрэг, хэрэгжилт



ЕБС-д зохион байгуулсан тэгш хамран сургах боловсролын жишиг хичээл (Биеийн тамир)

Medle.com-д байршуулсан видео хичээлүүдэд зориулан өөрийгөө үнэлэх ойлголтыг тандах тестүүдийг бэлтгэсэн. Видео хичээл үзсэнийхээ дараа уг тестэд хариулан ойлголтоо бататгах боломжтой юм.

Видео хичээлүүд болон ойлголтыг тандах тестийн линкийн жагсаалт руу дараах линк, эсвэл QR кодыг ашиглан нэвтэрч болно. Эдгээр видео хичээлийг аль болох олон хүнд хүргэн, бүх хүүхэд сургуулийн амьдралд дуртайяа оролцох боломжтой тэгш хамран сургах боловсролыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх болтугай.

URL:

<https://docs.google.com/spreadsheets/d/1b8KffBJWvphP46sS-h5RkjAAN4Hdcccdk/edit#gid=916808923>



Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Авзага трейд бьютинг, 505 тоот



<https://www.facebook.com/JICA.START.2>



<https://www.jica.go.jp/>



jicastart2@gmail.com



+976-80486690
+976-95937356

